

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа  
Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг  
эгүүлэн татах, томилуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мэндсайханы Энхсайхан, Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батлайн Чулуунхүү, Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Төмөрхүлэгийн Төгсбилгүүн нарыг тус тус эгүүлэн татах, Монгол Улсаас Шведийн Вант Улс, Австралийн Холбооны Улс, Тайландын Вант Улс, Япон Улс, Канад Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад тус тус суух Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилуулах саналыг оруулж байна.

Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нь Дипломат албаны тухай хуульд заасан Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх /7 дугаар зүйл/, Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний бүрэн эрх /10 дугаар зүйл/-ийг хэрэгжүүлэн суух, хавсран суух оронд Монгол Улсыг төлөөлөн, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал боловсруулах, хэрэгжүүлэн шийдвэрлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, улс орныхоо хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгаа хийх, холбогдох байгууллагад танилцуулах, хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэн Монгол Улсыг төлөөлөн хилийн чанадад ажилладаг билээ.

Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж буй албан хаагчид нь мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, гадаад хэлний өндөр мэдлэгтэй тул улс орноо хилийн чанадад төлөөлөн ажиллах өндөр хариуцлагатай, нэр хүндтэй албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР